



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХУУГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

САНХУУГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХУУГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН



2016 он

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
2015 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитын код: YAG-CAГ/2016/16-CTA-TE3

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: Enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас:
Цахим хаяг: Gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Л.Хонгорзул
Утас: 261729
Цахим хаяг: Khongorzull@audit.gov.mn

Шинжээч: А.Ариунзаяа
Утас: 261729
Цахим хаяг: Ariunzayaa@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар 15160
Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын гэрчилгээ.....	3
Аудитын тайлан.....	4
Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	4
Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	4
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	5
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	5
Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
Дотоод хяналт.....	6
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар.....	6
Шилэн дансны мэдээлэл.....	6
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	7
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар.....	7
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	7
Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	10
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	10
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
Зөрчилгүй санал дүгнэлт.....	10
Менежментийн захидал.....	12
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	18
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	18
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	20
АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	22
АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	24
АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН.....	25

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бөгө тойруу 3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, ДЭД ДАРГА Э.БАТБОЛД
ТАНАА

2016.04.22 № 686
танай _____ ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Санхүүгийн зохицуулах хорооны удирдлага нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор ауудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

10.10.20\Bichig_Khureg\Yewsan_Bichig\2016\0422SAG7.Docx
073426

АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан /УАГ-САГ/2016/16-СТА-ТЕЗ/-д аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитыг 2016 оны 4 дүгээр сарын 8-наас 2016 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, шинжээч А.Ариунзаяа нар хэрэгжүүлэв. /ЛАБ-СТА-А-9/

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2016 оны 3 дугаар сарын 30-ны 3/1023 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2016 оны 4 дүгээр сарын 8-наас 2016 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2016 оны 4 дүгээр сарын 25-нд Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулиудын нэг болох Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан, мөн "Журам шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалыг хүчингүй болгож, 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөхөөр заасан байна.

Мөн Сангийн сайдын "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 2015 оны 7 дугаар тушаалаар Сангийн сайдын "Эдийн засгийн ангилал батлах тухай" 2014 оны 5 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Сангийн сайдын "Төсвийн зарим анхдагч ангилал батлах тухай" 2014 оны 150 дугаар тушаалын 1,2,3 дугаар хавсралтуудыг тус тус хүчингүй болгосон байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хорооны эрхэм зорилго нь Монгол Улсад олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлэх явдал юм.

- Санхүүгийн зохицуулах хороо нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:
- Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах;
- Санхүүгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын оновчтой чиг хандлагыг тодорхойлох;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;
- Хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчдийн хүсэлт, гомдлыг хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх, тэдний эрх ашгийг хамгаалах зорилтууд байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-т "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн...", Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т "Ажлын албаны дарга нь Хорооны ерөнхий менежер байх...", Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан "Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм"-ийн 4.5-д "Хорооны ерөнхий менежерийн хувьд хорооны төсвийг захиран зарцуулах" гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д "төсвийн ерөнхийлөн захирагч... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэж заасныг тус тус баримтлан тайлагнасан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны төсвийн санхүүжилтийг Сангийн яамны Төрийн сангаас олгож байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон, тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Гүйцэтгэлийн шатанд төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 7 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 160 дугаар тогтоолоор батлуулж 2010 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөж эхэлсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг 2015 оноос "Emerald" санхүүгийн програмыг ашиглан гүйцэтгэж, санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан "ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэх аргачлал"-ын дагуу бэлтгэсэн байна.

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллага тул материаллаг байдлын суурийг тооцохдоо санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас сонгох нь зохимжтой гэж үзэн /ТАБ-СТА-А-4/ маягыг ашиглан нийт зардлын 2 хувиар тооцож /4,414.8 сая.төг х 2%/ 88.2 сая төгрөгөөр тогтоолоо.

Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Санхүүгийн зохицуулах хорооны Дотоод аудитын хэлтэс нь 2015 онд хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн гэсэн 3 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны Дотоод аудитын хэлтсийн 2015 оны ажлын төлөвлөгөөнд нийт 15 ажлыг гүйцэтгэхээр төлөвлөснөөс 2 ажлыг гүйцэтгэж, эд хөрөнгийн тооллогын комисст тус хэлтсийн 1 мэргэжилтэн ажилласан, иргэд ажилтан, албан хаагчдаас ирүүлсэн 12 өргөдөл гомдлыг хянан, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан бөгөөд 1 мэргэжилтэн нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамааралгүй ажил үүргийг гүйцэтгэсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансдаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны төсөв 4,158.3 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,703.5 сая төгрөг, бараа үйлчилгээний орлогоор 1,028.8 сая, нийт 3,732.3 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 3,941.4 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийн гүйцэтгэл 94.8 хувьтай байна.

Шилэн дансны мэдээлэл

"Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор байгууллагын <http://www.frc.mn> цахим хуудсанд "Шилэн данс" гэсэн тусгай цонх нээн хуулийн дагуу цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн боловч 73.4 сая төгрөгийн

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

зарлагын 5 гүйлгээний шийдвэрийн хуулбарыг оруулаагүй, төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгааны тайлбарыг дутуу мэдээлсэн зөрчлийг аудитын явцад залруулсан.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 7 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Санхүүгийн зохицуулах хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, сэлбэг зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Санхүүгийн зохицуулах хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны, "Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн 2015 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг нэгтгэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 94, 262 дугаар тогтоолуудаар 2 удаа бүтэц орон тоог шинэчлэн 144 хүний орон тоотойгоор ажиллахаар баталж, гүйцэтгэлээр 138 хүн ажилласан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын тушаалаар 2015 онд 45 ажилтныг ажлаас чөлөөлж, 52 ажилтныг ажлын байранд шинээр томилсон байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн. Үүнд:

1. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх" төслөөс үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн 9.7 сая төгрөгийн бараа материалыг хандив, тусламжийн орлогоор бүртгэсэн боловч Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны 2015 оны санхүүгийн үр дүнгийн тайланд тусламжийн орлогоор тайлагнаагүй нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 27-д *"Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой..."* гэж заасантай нийцээгүй ба Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал"-ын дагуу бэлтгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал"-ыг мөрдөж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагад зөвлөмж болгов.

2. Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайлангаас ерөнхий дэвтэр, журнал, тооллогын бүртгэл, анхан шатны баримт руу хөөн шалгахад өмнөх онуудад нийт 10.4 сая төгрөгийн сэлбэг, бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, элэгдэл тооцож ирсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 13-т "Үндсэн хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг эсвэл ижил шинж чанараар нь ангилсан хөрөнгийн бүлэглэл бөгөөд түүнийг санхүүгийн тайлангийн тодруулгад нэг зүйл болгон илэрхийлдэг", Сангийн сайдын "Эдийн засгийн ангилал батлах тухай" 2014 оны 5 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Балансын дансны ангилал" болон тус байгууллагын НБББББ-ийн 6.1.3.3 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийг орлогод авахдаа УСНББОУС 17 болон байгууллагын НБББББ-ийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 10.4 сая төгрөгийн бараа материалын асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэхийг Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагад зөвлөмж болгов.

3.Үндсэн хөрөнгийн элэгдлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-т заасан хувь хэмжээнээс зөрүүтэй тооцсон байна. Үүнд:

2007 онд ашиглалтанд орсон 175.1 сая төгрөгийн өртөгтэй агуулахын барилгын элэгдлийг 107.9 сая төгрөгөөр илүү тооцсон;

Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10 ширхэг принтер, 10 ширхэг компьютерт дахин элэгдэл байгуулж эд хөрөнгийг хасах үлдэгдэлтэйгээр тайлагнасан, номонд 1.2 сая төгрөгийн элэгдэл тооцсон;

4 жилээр элэгдүүлэхээр заасан зарим эд хөрөнгийн элэгдэл тооцох жилийг 5 жилээр т ооцож, элэгдлийг дутуу байгуулсан.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн элэгдлийн зөрүүг тооцож өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хуримтлагдсан үр дүнд залруулга хийсэн.

4.Ажлын албаны даргын тушаалаар цалингүй чөлөө олгосон, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн ажилтнуудын НДШ-д нийт 289.5 мянган төгрөг төлсөн нь Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "НДШ төлснөөр тооцогдох хугацаанд НДШ төлөх журам"-ын 2.а-д "хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч болон төрийн албан хаагч тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар ажлаас чөлөөлөгдөж өмчийн хэлбэр харгалзахгүйгээр их, дээд сургууль, коллеж болон мэргэжил дээшлүүлэх ба олгох курст суралцаж байгаа бол суралцах хугацааны жилд ногдох шимтгэлийг Засгийн газраас тогтоон мөрдүүлж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон ажил олгогчийн төлбөл зохих хувиар бодож захиалгаар суралцуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь жил бүрийн 1 дүгээр сард багтаан даатгалын зохих санд төлнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолыг зөрчиж зарцуулсан 289.5 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох;

5.Тайлант жилд байгууллагын имидж бүдүүлэх зорилгоор (Ажил гүйцэтгэгч нь захиалагчийн хүсэлтийн дагуу хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах гүүр болж, байгууллагын талаар эерэг имидж бүрдүүлэх) "Сайн амжилт их нээлт" ТББ-тай 2015 оны 2 дугаар сарын 26-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

Харин тус ТББ нь 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2015 оны 7 дугаар сарын 1-ний хооронд Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн зэрэг ажлын тайлангаа гаргаж ирүүлсэн бөгөөд энэ зардалд 9.0 сая төгрөг зарцуулсан,

ажиллагсдын хүүхдүүдэд бэлэг өгөхөд 2.2 сая, хорооны гишүүдийн хурлын хоолны зардалд 1.9 сая, нийт 13.1 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ зэрэг зардлаас зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар", "Хэмнэлтийн горимд шилжих тухай" Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар", "Хэмнэлтийн горимд шилжих тухай" Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг мөрдөж, зайлшгүй хэрэгцээтэй бус зардлыг тэвчиж, урсгал төсвийг хэмнэж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагад зөвлөмж болгов.

6.АОУС 510 "Аудитын эхний ажил-Эхлэлтийн баланс" дагуу 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдлийг тулган баталгаажуулахад АХБ-ны санхүүжилтээр 2012 оноос хэрэгжиж эхэлсэн "Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн санхүүгийн тайланг ТЕЗ-ийн өмнөх жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэж тайлагнаагүй байна.

Энэ нь АОУС 510-т "Санхүүгийн тайлангийн үзүүлэлт дотроос эхлэлтийн баланс нь тайлант хугацааны эхэнд оршин байсан болзошгүй зүйл, төлбөрийн амлалт зэрэг тодруулах шаардлагатай асуудлыг багтаадаг", Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т "ТЕЗ ... ЗГ-ын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайланг ...санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-д заасны дагуу ТЕЗ-ийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийлгэсэн.

7.Дотоод аудитын хэлтэс 2015 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, 1 мэргэжилтэн нь ажлын байрны тодорхойлолтод хамааралгүй ажил үүргийг гүйцэтгэж байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийг мөрдөж ажиллах талаар Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагад зөвлөмж өгөв.

8."Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн нэгжийн 2015 оны санхүүгийн тайланг бэлтгэхдээ өмнөх үеийн болон тайлант оны үр дүнг зэрэгцүүлэхүйц байдлаар тайлагнаагүй мөн аккруэл болон мөнгөн суурьт шалгах баланс бэлтгээгүй, ажил гүйлгээг Ерөнхий дэвтэр, журналд бүртгэж хөтлөөгүй, тайлант оны эцэст эд хөрөнгийн тооллого хийж, тооцоог баталгаажуулаагүй зэрэг нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д эд хөрөнгийн тооллогыг "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал"-ын дагуу иж бүрэн бэлтгэж тайлагнах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж, ажил гүйлгээг тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан дарааллаар гүйцэтгэж, ерөнхий дэвтэр, журнал хөтлөх талаар Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагад зөвлөмж өгсөн байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн зохицуулах хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 113.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 89.5 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 10.4 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж, 13.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгч, 289.5 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулах акт тогтоов.

Дээр дурдсан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 5 зөвлөмж өгсөн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Санхүүгийн зохицуулах хорооны төсвийн 2014 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Санхүүгийн зохицуулах хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2015 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Үндсэн хөрөнгийн талаар

Асуудал 2

Зардлын талаар

Асуудал 3

Санхүүгийн тайлагналын талаар

Асуудал 4

Санхүүгийн тайлагналын талаар

Асуудал 5

Дотоод хяналтын талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллагын энэхүү зөвлөмж нь Та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АСУУДАЛ 1: ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТАЛААР

YAГ-ын ажиглалт

Үндсэн хөрөнгийн дансанд 10.4 сая төгрөгийн бараа материалыг бүртгэж элэгдэл тооцсон нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө 13-т "Үндсэн хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг эсвэл ижил шинж чанараар нь ангилсан хөрөнгийн бүлэглэл бөгөөд түүнийг санхүүгийн тайлангийн тодруулгад нэг зүйл болгон илэрхийлдэг", Сангийн сайдын "Эдийн засгийн ангилал батлах тухай" 2014 оны 5 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Балансын дансны ангилал" болон тус байгууллагын НБББББ-ийн 6.1.3.3 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Үндсэн хөрөнгө болон элэгдлийн зардал үндэслэлгүйгээр нэмэгдэх;

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

YAГ-ын зөвлөмж

УСНББОУС 17 болон байгууллагын НБББББ-ийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй бараа материалыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

АСУУДАЛ 2: ЗАРДЛЫН ТАЛААР

ҮАГ-ын ажиглалт

Байгууллагын имидж бүдүүлэх зорилгоор "Сайн амжилт их нээлт" ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж 9.0 сая, ажиллагсдын хүүхдүүдэд бэлэг өгөхөд 2.2 сая, хорооны гишүүдийн хурлын хоолны зардалд 1.9 сая, нийт 13.1 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар", "Хэмнэлтийн горимд шилжих тухай" Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах.

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, "Хэмнэлтийн горимд шилжих тухай" Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

АСУУДАЛ 3: САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ТАЛААР

ҮАГ-ын ажиглалт

Үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн 9.7 сая төгрөгийн бараа материалыг ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн тайланд тусламжийн орлогоор тайлагнаагүй нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой..." гэж заасантай нийцээгүй, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал"-ын дагуу бэлтгээгүй байна.

Эрсдэлүүд

Орлого дутуу илэрхийлэгдэх

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал"-ыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

АСУУДАЛ 4: САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ТАЛААР

ҮАГ-ын ажиглалт

"Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн нэгжийн 2015 оны санхүүгийн тайланг бэлтгэхдээ өмнөх үеийн болон тайлант оны үр дүнг зэрэгцүүлэхүйц байдлаар тайлагнаагүй мөн аккурэл болон мөнгөн суурьт шалгах баланс бэлтгээгүй, ажил гүйлгээг Ерөнхий дэвтэр, журналд бүртгэж хөтлөөгүй, тайлант оны эцэст эд хөрөнгийн тооллого хийж, тооцоог баталгаажуулаагүй зэрэг нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д эд хөрөнгийн тооллогыг "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, заавар, журам зөрчсөн байх.

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

ҮАГ-ын зөвлөмж

Санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал"-ын дагуу иж бүрэн бэлтгэж тайлагнах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж, ажил гүйлгээг тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан дарааллаар гүйцэтгэж, ерөнхий дэвтэр, журнал хөтлөх. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно

АСУУДАЛ 5: ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР

ҮАГ-ын ажиглалт

Дотоод аудитын хэлтэс 2015 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, 1 мэргэжилтэн нь ажлын байрны тодорхойлолтод хамааралгүй чиг үүргийг гүйцэтгэж байгаа нь Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 3 дахь заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, заавар, журам зөрчсөн байх.

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

ҮАГ-ын зөвлөмж

Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	440,957,922.26	385,450,434.95
МӨНГӨН ХӨРӨНГӨ	291,708,349.61	312,615,298.16
Кассанд байгаа бэлэн мөнгө	4,560.00	4,560.00
Төгрөг	4,560.00	4,560.00
Гадаад валют		
Банкинд байгаа бэлэн мөнгө	291,703,789.61	312,610,738.16
Төгрөг	291,703,789.61	312,610,738.16
Төрийн сангийн харилцах	291,703,789.61	312,610,738.16
Монгол банкин дахь харилцах		
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
АВЛАГА	101,109,134.00	37,240,468.24
Ажиллагчидтай холбогдсон авлага	94,543.00	444,638.00
Бусад авлага	101,014,591.00	36,795,830.24
Байгууллагаас авах авлага	101,014,591.00	36,795,830.24
Хувь хүмүүсээс авах авлага		
БАРАА МАТЕРИАЛ	48,140,438.65	35,594,668.55
Түүхий эд материал	-	-
Хангамжийн материал	48,140,438.65	35,594,668.55
Бичиг хэргийн материал	12,635,851.37	20,170,767.47
Аж ахуйн материал		
Сэлбэг хэрэгсэл	3,480,000.00	
Түлш, шатах тослох материал	5,550,894.00	
Бусад хангамжийн материал	26,473,693.28	15,423,901.08
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,214,427,148.61	1,013,012,519.45
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,214,427,148.61	1,013,012,519.45
Газар		
Биет хөрөнгө	770,750,134.13	692,198,732.97
Барилга, байгууламж, орон сууц	175,147,872.00	175,147,872.00
Хуримтлагдсан элэгдэл	(124,043,976.87)	(19,126,307.60)
Авто-тээврийн хэрэгсэл	339,346,525.60	339,346,525.60
Хуримтлагдсан элэгдэл	(144,335,193.39)	(196,730,118.49)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	605,106,468.29	610,006,468.29
Хуримтлагдсан элэгдэл	(282,006,424.30)	(398,973,404.17)
Тавилга, аж ахуйн эд хогшил	232,190,419.18	232,190,419.18
Хуримтлагдсан элэгдэл	(88,371,672.62)	(108,381,181.84)
Бусад үндсэн хөрөнгө	2,498,435.00	579,975.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,582,318.76)	(579,975.00)
Дуусаагүй барилга, байгууламж	56,800,000.00	56,800,000.00
Ном		1,918,460.00
Биет бус хөрөнгө	443,677,014.48	320,813,786.48
Програм хангамж	505,660,599.90	505,660,599.90
Хуримтлагдсан элэгдэл	(66,623,585.42)	(188,385,419.14)
Бусад биет бус хөрөнгө	4,640,000.00	4,640,000.00
Хуримтлагдсан элэгдэл		(1,101,394.28)
Бусад хөрөнгө	-	-
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,655,385,070.87	1,398,462,954.40
НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,530,775.59	237,079,000.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,530,775.59	237,079,000.00
Богино хугацаат үнэт цаас	-	-
Богино хугацаат зээлийн өглөг	-	-

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
Өглөг	20,530,775.59	237,079,000.00
Ажилчидтай холбогдсон өглөг		
Бусад өглөг	20,530,775.59	237,079,000.00
Байгууллагад төлөх өглөг	20,530,775.59	237,079,000.00
Урт хугацаат зээл	-	-
Гадаад валют	-	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		
Засгийн газрын хувь оролцоо	1,634,854,295.28	1,161,383,954.40
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,634,854,295.28	1,161,383,954.40
Өмч: төрийн	569,052,417.79	569,052,417.79
-хувийн		
Хуримтлагдсан үр дүн	976,264,762.52	502,794,421.64
Өмнөх үеийн үр дүн		1,056,077,379.14
Тайлант үеийн үр дүн	(161,638,672.66)	
Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	1,137,903,435.18	(553,282,957.50)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,537,114.97	89,537,114.97
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,655,385,070.87	1,398,462,954.40

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,846,663,940.00	3,861,503,157.90
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,563,635,080.00	1,157,897,392.32
Нийтлэг татварын бус орлого	1,563,635,080.00	1,148,238,392.32
Төсөв байгууллагын өөрийн орлого	1,537,096,100.00	1,136,455,697.46
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,313,647,100.00	1,014,418,171.97
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	223,449,000.00	122,037,525.49
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
Бусад орлого	26,538,980.00	11,782,694.86
Тусламжийн орлого	-	9,659,000.00
Хандив тусламж /дотоод/		
Хандив тусламж /гадаад/		9,659,000.00
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,283,028,860.00	2,703,605,765.58
Улсын төвлөрсөн төсвөөс	2,281,433,660.00	2,703,605,765.58
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,281,433,660.00	2,703,605,765.58
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,001,595,200.00	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,001,595,200.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,179,125,520.00	4,414,786,115.40
УРСГАЛ ЗАРДАЛ	4,179,125,520.00	4,414,786,115.40
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,072,126,090.00	4,169,084,230.40
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,628,580,940.00	1,712,878,238.19
Үндсэн цалин	1,255,999,060.00	1,343,554,907.19
Нэмэгдэл	204,468,580.00	228,652,431.00
Унаа хоолны хөнгөлөлт	168,113,300.00	140,670,900.00
Урамшуулал		
Гэрээт ажлын хөлс		
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,129,700.00	178,928,235.84
Тэтгэврийн даатгал	160,129,700.00	114,443,312.33
Тэтгэмжийн даатгал		12,621,095.59
ҮОМШӨ-ний даатгал		16,094,775.96
Ажилгүйдлийн даатгал		3,670,465.82
Эрүүл мэндийн даатгал		32,098,586.14
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	226,114,850.00	253,268,330.00
Гэрэл, цахилгаан		
Түлш, халаалт		
Цэвэр, бохир ус		
Байрны түрээс	226,114,850.00	253,268,330.00
Хангамж, бараа материалын зардал	445,472,150.00	444,800,397.57
Бичиг хэрэг	112,658,630.00	61,592,095.12
Тээвэр, шатахуун	97,353,160.00	67,893,021.45
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	74,478,690.00	49,995,952.83
Ном, хэвлэл		54,061,305.30
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	160,981,670.00	211,258,022.87
Аж ахуйн материал худалдан авах зардал		
Эд хогшил, урсгал засварын зардал	21,877,800.00	3,205,370.00
Багаж, техник, хэрэгсэл		
Тавилга		
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
Урсгал засвар	21,877,800.00	3,205,370.00
Томилолт, зочны зардал	179,114,530.00	83,746,946.93
Гадаад албан томилолт	36,431,730.00	75,746,927.93
Дотоод албан томилолт	141,279,600.00	4,061,000.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,403,200.00	3,939,019.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,054,564,180.00	1,084,651,954.03
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	832,159,570.00	164,506,635.68
Бусад зардал	222,404,610.00	920,145,318.35
Орлогын татварын зардал		
Бараа үйлчилгээний бусад зардал	356,271,940.00	407,604,757.84
Бараа үйлчилгээний бусад зардал	223,449,000.00	122,122,724.56
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	132,822,940.00	285,482,033.28
Найдваргүй авлагын алдагдал		
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,999,430.00	245,701,885.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг	68,989,960.00	219,805,450.00
Засгийн газрын дотоод шилжүүлэг	68,989,960.00	219,805,450.00
Засгийн газрын гадаад шилжүүлэг		
Бусад урсгал шилжүүлэг	38,009,470.00	25,896,435.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,009,470.00	25,896,435.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	667,538,420.00	(553,282,957.50)
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	667,538,420.00	(553,282,957.50)

АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	82,624,318,930.00	74,303,312,160.50
ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,854,451,930.00	71,391,777,366.44
Нийтлэг татварын бус орлого	80,854,451,930.00	71,391,777,366.44
Хувьцааны ногдол ашиг		
Хүүгийн орлого		
Торгуулийн орлого	153,365,080.00	105,836,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	80,601,998,520.00	71,174,239,260.88
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,313,647,100.00	1,024,617,708.90
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,288,351,420.00	70,149,621,551.98
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
Бусад орлого	99,088,330.00	111,702,105.56
Тусламжийн орлого	-	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,769,867,000.00	2,911,534,794.06
Улсын төвлөрсөн төсвөөс	1,769,867,000.00	2,872,020,604.06
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,546,418,000.00	2,749,983,078.57
Оны эхний үлдэгдэлээс санхүүжих	223,449,000.00	122,037,525.49
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	39,514,190.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		39,514,190.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	82,624,357,340.00	74,293,503,460.15
УРСГАЛ ЗАРДАЛ	82,624,357,340.00	74,293,503,460.15
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,586,347,870.00	74,183,079,837.92
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,476,024,240.00	1,922,301,999.59
Үндсэн цалин	1,103,442,360.00	1,677,402,623.59
Нэмэгдэл	204,468,580.00	104,190,976.00
Унаа хоолны хөнгөлөлт	168,113,300.00	140,708,400.00
Урамшуулал		
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,129,700.00	182,738,700.00
Тэтгэврийн даатгал	160,129,700.00	182,738,700.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	194,807,870.00	226,220,330.00
Байрны түрээс	194,807,870.00	226,220,330.00
Ашиглалтын зардалд төлсөн		
Хангамж, бараа материалын зардал	136,971,800.00	111,187,980.05
Бичиг хэрэг	27,348,820.00	7,676,938.00
Тээвэр, шатахуун	25,910,750.00	51,823,527.45
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	68,662,230.00	45,252,614.60
Ном, хэвлэл		
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,050,000.00	6,434,900.00

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Бараа материал худалдан авахад төлсөн		
Эд хогшил, урсгал засварын зардал	-	8,674,120.00
Багаж, техник, хэрэгсэл		
Тавилга		
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
Урсгал засвар		8,674,120.00
Томилолт, зочны зардал	-	91,685,823.49
Гадаад албан томилолт		86,069,456.49
Дотоод албан томилолт		828,600.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		4,787,767.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,314,880,920.00	71,640,270,884.79
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		917,381,668.20
Бусад мөнгөн зарлага	80,314,880,920.00	70,722,889,216.59
Бараа үйлчилгээний бусад зардал	303,533,340.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	139,901,420.00	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	163,631,920.00	
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,009,470.00	110,423,622.23
Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
Засгийн газрын дотоод шилжүүлэг		
Засгийн газрын гадаад шилжүүлэг		
Бусад урсгал шилжүүлэг	38,009,470.00	27,252,493.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,009,470.00	27,252,493.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	83,171,129.23
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
Төвлөрүүлэх шилжүүлэг		83,171,129.23
Хөрөнгийн		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(38,410.00)	9,808,700.35
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	11,098,250.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Хүлээн авсан хүүний орлого		11,098,250.00
Хүлээн авсан ногдол ашиг		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	11,098,250.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(38,410.00)	20,906,950.35
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		291,708,349.61
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		312,615,298.16

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	569,052,417.79	89,537,114.97	(161,638,672.66)	496,950,860.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	569,052,417.79	89,537,114.97	(161,638,672.66)	496,950,860.10
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			1,137,903,435.18	1,137,903,435.18
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	569,052,417.79	89,537,114.97	976,264,762.52	1,634,854,295.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			79,812,616.62	79,812,616.62
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	569,052,417.79	89,537,114.97	1,056,077,379.14	1,714,666,911.90
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			(553,282,957.50)	(553,282,957.50)
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	569,052,417.79	89,537,114.97	502,794,421.64	1,161,383,954.40

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		291,708,349.61	291,708,349.61	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,158,308,000.00	3,941,432,190.00	(216,875,810.00)	-5.22
УРСГАЛ ЗАРДАЛ	4,158,308,000.00	3,941,432,190.00	(216,875,810.00)	-5.22
БАРАА, АЖИЛ	3,907,321,600.00	3,692,180,700.00	(215,140,900.00)	-5.51
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ				
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,661,259,900.00	1,922,302,000.00	261,042,100.00	15.71
Үндсэн цалин	1,438,875,700.00	1,677,402,620.00	238,526,920.00	16.58
Нэмэгдэл	222,384,200.00	244,899,380.00	22,515,180.00	10.12
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,738,700.00	182,738,700.00	-	0.00
Тэтгэврийн даатгал	182,738,700.00	182,738,700.00	-	0.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	251,087,600.00	226,220,330.00	(24,867,270.00)	-9.90
Байрны түрээс	251,087,600.00	226,220,330.00	(24,867,270.00)	-9.90
Хангамж, бараа материалын зардал	270,848,500.00	342,007,540.00	71,159,040.00	26.27
Бичиг хэрэг	12,975,200.00	7,676,940.00	(5,298,260.00)	-40.83
Тээвэр, шатахуун	10,905,800.00	51,823,530.00	40,917,730.00	375.19
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	46,265,600.00	45,252,610.00	(1,012,990.00)	-2.19
Ном, хэвлэл	192,290,000.00	230,819,560.00	38,529,560.00	20.04
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,411,900.00	6,434,900.00	(1,977,000.00)	-23.50
Эд хогшил, урсгал засварын зардал	41,000,200.00	8,674,120.00	(32,326,080.00)	-78.84
Урсгал засвар	41,000,200.00	8,674,120.00	(32,326,080.00)	-78.84
Томилолт, зочны зардал	207,430,900.00	10,575,540.00	(196,855,360.00)	-94.90
Гадаад албан томилолт	5,358,600.00	4,959,170.00	(399,430.00)	-7.45
Дотоод албан томилолт	200,792,200.00	828,600.00	(199,963,600.00)	-99.59
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,280,100.00	4,787,770.00	3,507,670.00	274.02
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,200,300.00	917,381,670.00	103,181,370.00	12.67
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	814,200,300.00	917,381,670.00	103,181,370.00	12.67
Бараа үйлчилгээний бусад зардал	478,755,500.00	82,280,800.00	(396,474,700.00)	-82.81
Бараа үйлчилгээний бусад зардал	478,755,500.00	82,280,800.00	(396,474,700.00)	-82.81
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,986,400.00	249,251,490.00	(1,734,910.00)	-0.69
Засгийн газрын урсгал шилжүүлэг	222,120,000.00	221,999,000.00	(121,000.00)	-0.05

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Засгийн газрын гадаад шилжүүлэг	222,120,000.00	221,999,000.00	(121,000.00)	-0.05
Бусад урсгал шилжүүлэг	28,866,400.00	27,252,490.00	(1,613,910.00)	-5.59
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,866,400.00	27,252,490.00	(1,613,910.00)	-5.59
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,158,308,000.00	3,732,339,130.00	(425,968,870.00)	-10.24
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,132,308,000.00	2,703,605,770.00	(428,702,230.00)	-13.69
Улсын төсвөөс санхүүжих	3,132,308,000.00	2,703,605,770.00	(428,702,230.00)	-13.69
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,022,700,000.00	1,014,273,170.00	(8,426,830.00)	-0.82
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,022,700,000.00	1,014,273,170.00	(8,426,830.00)	-0.82
БУСАД ЭХ ҮҮСВЭР	3,300,000.00	14,460,190.00	11,160,190.00	338.19
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	3,300,000.00	14,460,190.00	11,160,190.00	338.19
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		312,615,298.16	312,615,298.16	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	131.00	138.00	7.00	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	131.00	138.00	7.00	
Удирдах ажилтан	20.00	28.00	8.00	
Гүйцэтгэх ажилтан	101.00	101.00	-	
Үйлчлэх ажилтан	10.00	9.00	(1.00)	
Гэрээт ажилтан			-	